



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2013 оны 02 сарын 06 өдөр

Дугаар 44

Улаанбаатар хот

“Э-Транс ложистикс” ХК-ийн үнэт цаасыг  
тусгаарлалтаас чөлөөлөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.1.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.1, нэр бүхий 4 хувьцаа эзэмшигчдээс Хороонд хандан ирүүлсэн хүсэлтийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн 26 дугаар тогтоолын 3 дахь хэсгээр тусгаарласан хавсралтанд дурьдсан нэр бүхий 4 хувьцаа эзэмшигчдийн “Э-Транс ложистикс” ХК-ийн энгийн хувьцааг 2012 оны 02 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн тусгаарлалтаас чөлөөлсүгэй.

2. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА Д.БАЯРСАЙХАН



Санхүүгийн зохицуулах хорооны  
2013 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн  
44 дүгээр тогтоолын хавсралт

“Э-Транс ложистикс” ХК-ийн хувьцаа эзэмшигчид

Д/д	Хувьцаа эзэмшигчдийн нэрс
1	“Э-Транс” ХХК
2	“Монголиан Транспортэйшн холдинг” ХХК
3	“Би Ди Пи Эф” ХХК
4	Х.Батхишиг